

АШУҮИС-ийн захирлын 2015 оны
.....дүгээр сарынны өдрийн
..... тоот тушаалын I хавсралт

АШУҮИС-ийн суралцагчийг үнэлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. АШУҮИС-ийн бүхий л түвшний (төгсөлтийн өмнөх, төгсөлтийн, төгсөлтийн дараах) сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн хөтөлбөрийн дагуу суралцагчийн цогц чадамжийг үнэлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. Журмын хэрэгжилтэнд Сургалтын бодлого зохицуулалтын газар, бүрэлдэхүүн, салбар сургуулиуд болон холбогдох тэнхмүүд хамтран хяналт тавина.

Хоёр. Суралцагчийг үнэлэх аргачлал

- 2.1. Хичээлийн хөтөлбөр, стандартад заагдсан аргачлалын дагуу суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд А,В,С,D,F гэсэн үсгэн болон процентон дүн хэрэглэнэ.
- 2.2. Оюутны хичээлийн төгсгөлийн дүн (явц болон шалгалтын нийлбэр) 60%, резидентийн шалгалтын дүн 70%, магистрантын шалгалтын дүн 70%, докторантын шалгалтын дүн 80% ба түүнээс дээш тохиолдолд тухайн хичээлийн шалгалтанд тэнцсэнд тооцно.
- 2.3. Процентон дүнг бүхэл тооны нарийвчлалтайгаар гаргаж, харгалзах чанарын оноог зааврын дагуу тохируулан тооцно. (Хүснэгт-1)

Процентон дүнд харгалзах чанарын оноо

Хүснэгт-1

Үсгэн үнэлгээ	Процентон дүн	Чанарын оноо
А	100	4
	99	3.95
	98	3.9
	97	3.85
	96	3.8
	95	3.75
	94	3.7
	93	3.65
	92	3.6

	91	3.55
	90	3.5
B	89	3.45
	88	3.4
	87	3.35
	86	3.3
	85	3.25
	84	3.2
	83	3.15
	82	3.1
	81	3.05
	80	3
	C	79
78		2.8
77		2.7
76		2.6
75		2.5
74		2.4
73		2.3
72		2.2
71		2.1
70		2
D	69	1.9
	68	1.8
	67	1.7
	66	1.6
	65	1.5
	64	1.4
	63	1.3
	62	1.2
	61	1.1
	60	1

2.4. Оюутны хичээлийн төгсгөлийн процентон дүн нь явцын ба шалгалтын дүнгийн нийлбэрээс бүрдэнэ. Төгсгөлийн дүнд эзлэх явцын болон шалгалтын дүнгийн харьцаа 70:30 байна.

2.5. Явцын дүнг дараах аргачлалыг үндэслэн тооцно:

2.5.1. Явцын дүнг гаргахдаа тухайн хичээлийн хөтөлбөр, стандартад заасан бүрэлдэхүүн хэсгүүдийг оруулан тооцно. (багш өөрийн хичээлийн онцлогоос хамааруулан өөрчилж болно)

$$E_{70}=A_1+A_2+A_3+....A_n$$

Үүнд:

- E₇₀ явцын дүн
- A₁ хичээлийн ирц
- A₂ онолын мэдлэгийн түвшин
- A₃ лаборатори, дадлага, семинарын хичээлийн даалгаврын биелэлт
- A_n бие даан судлах даалгаврын биелэлт

2.5.2. Эмнэлзүйн сургалтын өвчтөн үзэх, өвчний түүх бичих, гардан үйлдлийн ур чадвар, жижүүр хийх, эмнэлзүйн ярилцлага, харилцаа хандлага, эмнэлзүйн тохиолдол шийдвэрлэх байдал зэргийг явцын дүнд тусгана.

2.6. Дараах тохиолдолд явцын үнэлгээг “үл тооцов” гэж тэмдэглэн тухайн хичээлийн шалгалтанд оруулахгүй.

2.6.1. Хичээлийн явцын процентон дүн 60%-аас бага

2.6.2. Тасалсан, чөлөө авсан дадлага, семинарын хичээлийг тогтоосон хугацаанд нөхөж дуусгаагүй.

2.6.3. Хичээл, блокын 25%-аас дээш дадлага, семинарыг хүндэтгэх шалтгаангүйгээр тасалсан.

2.7. Явцын дүнгийн амжилтаас хамаарч шалгалтаас чөлөөлөхгүй.

2.8. Хичээлийн явцын дүнд “үл тооцов” үнэлгээ авсан тохиолдолд ноогдох цагийн хөлсийн 50 хувийг төлж нөхөн суралцана.

2.9. Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг харгалзан шалгалтын дараах арга, хэлбэрүүдээс тохиромжтойг нь сонгоно. (Хүснэгт-2)

Шалгалтын хэлбэрүүд

Хүснэгт-2

Мэдлэг үнэлэх шалгалт	Ур чадвар үнэлэх шалгалт	Цогц чадамжийг үнэлэх шалгалт
Аман шалгалт	ТЗЭШ, ТЗГШ	ТЗЭШ, ТЗГШ
Эссэ бичих, бичгэн шалгалт	Өртөөчилсэн шалгалт	360 хэмийн үнэлгээ (зөвхөн хандлага харилцааг үнэлнэ)
Олон хувилбарт сорил (А, К, В, Е хэлбэрийн)	Урт болон богино хэлбэрийн эмнэлзүйн тохиолдол	Эмнэлзүйн дасгал үнэлгээ (Mini-CEX)
Компьютерт суурилсан сорил (е-сорил)	Гардан шалгалт	Гардан гүйцэтгэлийн ажиглалтын үнэлгээ (DOPS)
Эмнэлзүйн тохиолдолд суурилсан сорил	Өвчтөний менежмент	Портфель үнэлгээ

Бусад	Бусад	Бусад
-------	-------	-------

2.10. Төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтанд суралцагчид тайлан хамгаалалтанд улирал тутам оролцож, явцын үнэлгээ хийлгэсэн байна.

Гурав. Үнэлгээний зохицуулалт

- 3.1. Багш дүнгийн хуудсыг хэвлэн гаргаж, гарын үсгээр баталгаажуулан, хариуцсан алба, нэгжид шалгалт дууссанаас хойш 48 цагийн дотор хүлээлгэж өгнө.
- 3.2. Үнэлгээний маргаан гарсан тохиолдолд дүнгийн хэвлэмэл хуудсыг баримтлан шийдвэрлэнэ.
- 3.3. Оюутан, магистрант, докторантуудын шалгалтын дүн, хичээл нөхөлтийг “АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам”-ын дагуу Их сургуулийн удирдлага мэдээллийн системд оруулна.
- 3.4. Оюутны зуны дадлагыг “АШУҮИС-ийн Зуны дадлагын журам”-д заасны дагуу үнэлнэ.

Дөрөв. Голч дүн

- 4.1. Суралцсан хугацаанд хөтөлбөрийн агуулга эзэмшилтийн чанарын түвшинг тогтооход голч дүнг ашиглана.
- 4.2. Их сургуулийн удирдлага мэдээллийн систем дэх суралцагчийн дүнгийн бүртгэлийг үндэслэн голч дүнг гаргана
- 4.3. Голч дүнг гаргахдаа суралцсан хугацаанд судалсан хичээл, блок бүрийн багц цагийг уг хичээлд авсан эцсийн харгалзах чанарын оноогоор харгалзуулан тус тусад нь үржүүлэн хооронд нь нэмээд гарсан нийлбэрийг тухайн хугацаанд судалсан хичээлүүдийн багц цагийн нийлбэрт хуваана.

$$\text{ҮГД} = \frac{K_1 \cdot O_1 + K_2 \cdot O_2 + \dots + K_n \cdot O_n}{K_1 + K_2 + K_3 + \dots + K_n}$$

Үүнд:

$K_1 + K_2 + K_3 \dots K_n$ - хичээлийн кредит

$O_1 + O_1 + O_1 \dots O_n$ - процентон дүнд харгалзах чанарын оноо

Тав. Дахин шалгалт өгөх

- 5.1. Хүндэтгэх шалтгааны улмаас шалгалтанд ороогүй оюутан шалгалтыг нөхөж өгөх бөгөөд тухайн суралцагчийн хувьд уг шалгалтыг эхний шалгалт гэж тооцно.
- 5.2. Хүндэтгэх шалтгаангүйгээр шалгалтанд ороогүй бол шалгалтын дүнг F (0%) гэж тооцно.
- 5.3. Дүн ахиулах зорилгоор шалгалт дахин өгөхийг зөвшөөрөхгүй.

- 5.4. Оюутан, магистрант, докторантуудын хувьд дахин шалгалтын төлбөр нь тухайн дамжааны 1 кредитэд ноогдох төлбөрийн 50 хувьтай тэнцүү байна
- 5.5. Төгсөлтийн дараах сургалтанд суралцагч нь тайлан хамгаалалтыг тооцуулаагүй, явцын шалгалтанд тэнцээгүй тохиолдолд дахин шалгалтын төлбөр нь сургалтын 1 багц цагийн үнэлгээтэй тэнцүү байна
- 5.6. Суралцагч хичээл, блокийн шалгалтанд F дүн, ТЗГШ ; ТЗЭШ шалгалтанд F, D дүн авсан тохиолдолд дахин нэг удаа шалгалт өгөх эрхтэй.
- 5.7. Дахин шалгалтыг зөвхөн Их сургуулийн удирдлага мэдээллийн систем дэх бүрэлдэхүүн сургуулиас гаргасан дахин шалгалт өгөх оюутны нэрсийг үндэслэн зохион байгуулна.
- 5.8 Сургалт хариуцсан албанаас баталсан хуваарийн дагуу суралцагчийн дахин шалгалтыг тухайн улиралдаа багтаан 1 удаа зохион байгуулна.

